

“7-р сарын 1. Хэвлэл мэдээллийн мониторинг”

Хоёр. ХМХ хүний эрхийн зөрчлийн тухай мэдээлсэн нь

Долоон сарын нэгний үйл явдалтай холбоотой нийт мэдээллийн хувийн жинг авч үзвэл, хүний эрхтэй холбоотой мэдээлэл телевизэд 14.2 (15 цаг) хувь, сонинд 10.4 (12347 см²) хувь эзэлсэн байна. Ийм мэдээлэл 7 сарын 1-ний өдөр дөнгөж 0.4 хувьтай байсан бол онц байдлын үеэр 11.1 хувь, онц байдлын дараа 22.8 хувь болж, бараг 57 дахин нэмэгджээ.

- Хүний эрхтэй холбоотой нийт мэдээллийн 97,3 хувийг хүний эрхийн зөрчил гарсан тухай мэдээлэл эзэлж байна.
- “Хүний эрхийн зөрчил гараагүй” гэсэн мэдээлэл 2.7 хувийг эзэлсэн байна. Үүнийг Хүний эрхийн комисс, Цагдаагийн байгууллага, Улсын Мөрдөн байцаах газар, УИХ-ын Хүний эрхийн дэд хороо, МАХН, зарим иргэн хэлжээ. Харин хүний эрхийн чиглэлээр ажилладаг ТББ-ууд, иргэний хөдөлгөөн, өмгөөлөгч, хохирогчдын ар гэрийнхэн, зарим нам эвсэл “Хүний эрхийн зөрчил ихээр гарч байна” гэсэн дүгнэлт өгч, мэдээлэл хийжээ
- “Хүний эрх зөрчигдөөгүй” гэсэн мэдээлэл 7 сарын 1-ний өдөр гараагүй, харин онц байдал тогтсон буюу МҮОНТВ ажиллаж байх үед 14,8 хувьтай байжээ. Онц байдлын дараахь дөрөв хоногийн ийм мэдээлэл 85,2 хувь хүрч, эрс нэмэгджээ
- Телевизээр дамжуулсан хүний эрхийн тухай нийт мэдээллийн 28 хувийг Ийгл телевиз, 25 хувийг С1 телевиз, 22 хувийг МҮОНТВ бүрдүүлж байна. Зөвхөн энэ гурван сувгийн хүний эрхийн тухай мэдээлэл 7 сарын 1-ний үйл явдалтай холбоотой нийт мэдээллийн 75 хувийг эзэлжээ.
- Өдөр тутмын сонинуудад нийтлэгдсэн хүний эрхийн нийт мэдээллийн 44 хувь нь “Өдрийн сонин”-д нийтлэгдсэн нь хамгийн өндөр үзүүлэлт болж байна.
- Хэвлэл мэдээллийн хэрэгслүүд хүний эрхийн зөрчлийн нийт 30 орчим төрлийн зөрчлийн тухай мэдээлжээ. Үүнээс баривчлагдсан иргэдэд цагдаа, хүчний байгууллагын зүгээс бие махбодын дарамт учруулах явдал байгаа тухай мэдээллийн 21.4 хувийг телевиз, 22.2 хувийг сонин мэдээлсэн нь хамгийн их яригдсан сэдэв байв. Харин нас барсан, шархадсан, баривчлагдсан хүмүүсийн ар гэрийнхэнд хэлж дуулгаагүй, өвчтэй хүн хоригдож байгаа, цагдаа, иргэдээс мөнгө, эд зүйл авсан, хөгжлийн бэрхшээлтэй/оюуны хомдолтой хүнийг баривчилсан тухай мэдээлэл хамгийн бага буюу тус бүр 0.1 хувийг эзэлжээ.
- ХМХ-үүд хүний эрхийн зөрчлийн тухай мэдээлэхдээ үзэл бодлоос илүү баримтад түшиглэн, эх сурвалжийн тоо, төлөөллийг харьцангуй мэргэжлийн түвшинд хангасан хэдий ч агуулгын хувьд авч үзвэл, хүний эрхийн зөрчлийн тухай бодитой мэдээлэл хүргэж чадаагүй байна. Тухайлбал:

“7-р сарын 1. Хэвлэл мэдээллийн мониторинг”

- Хүний эрхийн зөрчлийн тухай мэдээллийн эх сурвалжийг авч үзвэл, телевизийн сувгууд дунджаар нэг эх сурвалж ашиглан мэргэжлийн стандартаа зөрчсөн байна. Харин TV9 сувагт эх сурвалжийн тоо тэнцүү байлаа
 - Сонин дунджаар хоёр эх сурвалж ашиглаж, сонин мэргэжлийн стандартаа хангажээ. “Өдрийн сонин”-д бусдаас илүү тэнцүү тооны эх сурвалж ашигласан байна.
 - ХМХ-үүд хүний эрхийн зөрчлийн тухай мэдээлж, сурвалжлахдаа эх сурвалжийн төлөөллийг харьцангуй тэнцвэртэй ашигласан байна. Телевизийн хувьд, эх сурвалжийн 23.5 хувь нь албаны, 22.9 хувь нь ТББ, холбоодын, 21.4 хувь нь иргэдийн төлөөлөл байв. Сонины эх сурвалжийн 24.7 хувь нь албаны, 38.4 хувь нь иргэдийн төлөөлөл байв
- Хүний эрхийн зөрчлийн тухай мэдээллийн агуулга, сэдэвт шинжилгээ хийж үзэхэд, нийт 30 төрлийн зөрчил нийтлэгдсэн байв. Тухайлбал, баривчлагдсан иргэдийг цохиж зодох зэргээр бие махбодын эрүү шүүлтийн хэлбэр (21,4 хувь), Насанд хүрээгүй хүүхэд, жирэмсэн эмэгтэйчүүдийг албадан баривчилж, зодож, хүнлэг бус хандсан (12,8 хувь), хөгжлийн бэрхшээлтэй иргэний эрхийг зөрчсөн (10.5 хувь) зэрэг зөрчлийн тухай түлхүү мэдээлжээ. Тодруулбал, телевизүүд цагдаа, хүчний байгууллагын зүгээс зөрчилт нөхцөл байдалтай холбоотойгоор баривчлагдсан иргэдэд бие махбодын дарамт учруулах явдал гарч байгаа тухай мэдээллийг хамгийн олон давтамжтай нэвтрүүлсэн байна
 - Онц байдлын үеэр ажилласан МҮОНТВ-д мэдээллийн нэг эх сурвалж давамгайлж, төлөөллийн хувьд 58.2 хувь нь албаны хүмүүс байсан нь тэнд төрийн цензур үйлчилж, хүний эрхийн асуудалд зөвхөн төрийн байгууллагын байр суурийг дамжуулж байсныг нотолж байна.
 - “Хүний эрх зөрчигдсөн” тухай иргэн, төрийн бус байгууллага, сэтгүүлчийн өгсөн зургаан мэдээлэл 7 сарын 1-ний өдөр телевизээр цацагдсан бол онц байдлын үеэр төрийн бус байгууллагын төлөөллийн байр суурь 1.9 хувь, иргэдийн төлөөлөл 5.1 хувь болон буурч, онц байдал цуцлагдсаны дараа төрийн бус байгууллагын төлөөлөл 27.6 хувь, иргэдийн төлөөллийн байр суурь 25 хувь хүрч нэмэгджээ. Нийт мэдээллийн 26.9 хувьд сэтгүүлч хүний эрхийн зөрчлийн тухай мэдээлсэн байна. Албаны эх сурвалжийн байр суурь 30.8 болж буурсан ч бусадтай харьцуулахад хамгийн их хэвээр байлаа. Телевизийн сувгаас Ийгл телевизэд эх сурвалжийн байр суурийг хамгийн тэнцвэртэй байв.
 - Төрийн цензуртэй телевизийн ганц суваг ажиллаж байсан онц байдлын үеэр сонин иргэдийн дуу хоолойг түлхүү хүргэсэн байна. Иргэдийн төлөөллийн байр суурь сонинд нийтлэгдсэн хүний эрхтэй холбоотой нийт мэдээллийн 53,2 хувийг эзэлжээ

Хүний эрхийг дээдэлдэг ардчилсан нийгэмд ХМХ өөрөө хүний эрх зөрчихгүй байх хүмүүнлэг ёс, дэг журам үйлчилдэг. ХМХ, сэтгүүлчид нийтийг хамарсан, гэнэтийн, зөрчилт ийм үйл явдлын үеэр хүний эрх зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх ёстой. Харамсалтай нь, манай ХМХ-д ийм соёл, дагаж мөрдөх журам дүрэмгүй учир 7 сарын 1-ний өдөр, түүний дараа хүний эрхийг зөрчих явдал гарчээ.

“7-р сарын 1. Хэвлэл мэдээллийн мониторинг”

Телевизүүд шууд сурвалжлага хийх, ярилцлага хийхдээ гэрч, хохирогсдын нүүрийг нууцлах, дуу хоолойг нь өөрчлөх зэрэг хувиргалтын арга ашигласангүй. Энэ нь ЦЕГ-ын албадлага, шаардлагаар телевизийн сувгуудаас авсан үйл явдлын бичлэгийг сэжигтэн, баривчлагсдын эсрэг ашиглах боломж олгосон байна. Телевизийн сэтгүүлчид цагдааг нотлох баримтаар хангах гэж бус олон нийтийг мэдээллээр хангах гэж үйл явдлыг сурвалжилдаг билээ.